



ХЯМД ЭХ ҮҮСВЭРТЭЙ
ТӨСЛИЙН ЗЭЭЛИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ

ХОЁР ҮЕ ШАТТТАЙ ЖАЙКА ТӨСЛИЙН ЗЭЭЛ

Төслийн зорилго

- Ядуурлыг бууруулж, тогтвортой хөгжлийг дэмжих;
- Жижиг дунд бизнес эрхлэгчдэд урт хугацааны санхүүгийн дэмжлэг үзүүлж хувийн хэвшлийг хөгжүүлэх;
- Байгаль орчныг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах;
- Төсөлд оролцогч банкууд болон ЖДҮ бизнес эрхлэгчдийг чадавхжуулах.

Зээлийн дээд хэмжээ	25,000,000 - 800,000,000 төгрөг буюу түүнтэй тэнцэх ам.доллар
Хугацаа	3-10 жил (үндсэн зээлээс 36 сар хүртэл чөлөөлнө)
Валют	MNT, USD
Хүү	6 сар тутам хувьсах хүүтэй. 2021 оны сүүлийн хагас жилд мөрдөгдөх зээлийн хүү: төгрөг - 7%, ам.доллар 4.75%

Санхүүжүүлэх салбар

Хот, хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа жижиг, дунд бизнес эрхлэгчдийн дор дурьдсан бодлогын тэргүүлэх чиглэлийн төслүүдийг санхүүжүүлнэ. Үүнд:

- Импортыг орлуулах, экспортыг дэмжих;
- Дэвшилтэт технологи нэвтрүүлэх;
- Технологийн дамжлагатай, нэмүү өртөг шингээсэн;
- Ажлын байр нэмэгдүүлэх;
- Нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий бусад чиглэлүүд болно.

Санхүүжүүлэхийг хориглосон салбар

- Жижиглэнгийн болон бөөний худалдаа;
- Нийгмийн ёс суртахуунд харш, зугаа цэнгээний зориулалттай үйл ажиллагаа;
- Үл хөдлөх хөрөнгийн бизнес болон орон сууцны зориулалтаар барилга барих, түрээслүүлэх;
- Байгаль орчинд сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа;
- Өмнөх өр зээлээ барагдуулах;
- Цэрэг дайны зориулалттай үйл ажиллагаа;

- Хэрэглээний зээл;
- Хувь хүний бизнесийн зээл;
- Уул уурхайн олборлолт;
- Архи, тамхины үйлдвэрлэл ;
- Эргэлтийн хөрөнгө.

Бүрдүүлэх бичиг баримт

1. Төслөө боловсруулсан байх (төсөл хэрэгжих боломжийн судалгаа, хөрөнгө оруулалтын задаргаа, ашиг орлогын тооцоолол хийсэн байх);
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ болон шаардлагатай тохиолдолд нарийвчилсан үнэлгээ хийсэн байх;
3. ЖДҮ-н тодорхойлолт авсан байх;
4. Банкнаас тавигдаж буй бусад шаардлагуудыг хангах.

Анхаарах зүйлс

- Монгол улсад бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулдаг ААН;
- Монгол талын хувийн өмч давамгайлсан (51%≤) байх;
- Үндсэн ажилчдын тоо үйлдвэрлэл эрхэлдэг бол 200 хүртэл, үйлчилгээ үзүүлдэг бол 50 хүртэл байх;
- Зээлээр хэрэгжүүлэх төслийн санхүүгийн хөрөнгө оруулалтын дотоод өгөөж 13% ба түүнээс дээш байх;
- Зээлийн сайн түүхтэй байх;
- Төслийн нийт санхүүжилтийн 20 ≤хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх чадвартай байх;
- Байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх.

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЭХ ҮҮСВЭР, ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН БАТЛАН ДААЛТТАЙ ТӨСЛИЙН ЗЭЭЛ

Төслийн зорилго

Барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг болон жижиг, дунд бизнес эрхлэгчдэд бизнесээ өргөжүүлэх, шинэ төсөл хэрэгжүүлэх боломжийг олгох зорилготой бөгөөд харилцагч Та зээлээр үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмж худалдан авах, эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэх боломжтой.

Зээлийн дээд хэмжээ	920 сая төгрөг хүртэл
ЗБДаалтын хэмжээ	30-60% /420 сая төгрөг хүртэл/
Хугацаа	10 жил хүртэл
Валют	MNT
Хүү	12%-15%

Санхүүжүүлэх салбар

МУ-ын ЖДҮ-ийн тухай хуульд заасан тодорхойлолтод нийцсэн ЖДҮЭ бөгөөд энэ тухай гэрчилгээ эсвэл тодорхойлолт авсан ААН-д олгоно.

Санхүүжүүлэхийг хориглосон салбар

- Барилга угсралт, дэд бүтэц;
- Согтууруулах ундаа, тамхины үйлдвэрлэл худалдаа /үүнд шар айраг болон дарс хамаарахгүй/;
- Уул уурхай, ашигт малтмал, хайгуул олборлолт;
- Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх үйл ажиллагаа, ус хангамж, хаягдал бохир усыг цэвэрлэх үйл ажиллагаа;
- Санхүүгийн үйл ажиллагаа /Ломбард, сугалаа, даатгал гэх мэт/;
- Тансаг хэрэглээний бүтээгдэхүүний импорт;
- Томоохон аж ахуйн нэгжийн охин компани.

Бүрдүүлэх бичиг баримт

1. Зээлийн өргөдөл (Банкны салбараас эсвэл энд дарж татаж авна уу);
2. Жижиг дунд үйлдвэр, бизнес эрхлэгчээр бүртгүүлсэн гэрчилгээ эсвэл тодорхойлолт;
3. Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм;
4. Зээл авах, компанийн үл хөдлөх хөрөнгийг барьцаанд тавихыг зөвшөөрсөн хувь нийлүүлэгчдийн зөвшөөрөл;
5. Компанийн удирдах ажилтны иргэний үнэмлэхний хуулбар, анкет;
6. Компанийн товч танилцуулга;
7. Хэрэгжүүлэх төслийн танилцуулга (Загварыг банкны салбараас авна уу);
8. Санхүүгийн тайлан (сүүлийн 1-2 жилийн);
9. Үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, лиценз (шаардлагатай тохиолдолд);
10. Барьцаа хөрөнгийн гэрчилгээ, газар эзэмших гэрчилгээ /эх хувиар/;
11. Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой гэрээ хэлцлүүд;
12. Орлого, зардал, өглөг, авлага, санхүүжилтийг нотлох анхан шатны баримтууд;
13. Зээл хүсэгч компани, хувь нийлүүлэгчдийн нэр дээр авсан үл хөдлөх хөрөнгө эзэмшлийн дэлгэрэнгүй лавлагаа;
14. Бусад шаардлагатай баримт бичгүүд.

Анхаарах зүйлс

60% хүртэл буюу нэг зээлдэгчид олгох батлан даалтын дээд хэмжээ 420,0 сая төгрөг байна.



ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ:

Утас: +976 1900-1977

И-мэйл: info@tdbm.mn

Вэб хаяг: www.tdbm.mn